

НОМ ЗҮЙ, ЛАВЛАХ

**МАНЖУУРЫН ХУВЬСГАЛТ  
БААЗЫН ТАЛААРХИ  
ШИНЭ БҮТЭЭЛ****О. Борисов. «Зөвлөлт Холбоот улс ба манжуурын хувьсгалт бааз, (1945—1949)» нэмж засварласан гурав дахь хэвлэл, М., 1985\***

Өгүүлэн бүхий ном нь Хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн шийдвэрлэх ач холбогдол бүхий нэн хариуцлагатай үе шат болох 1945—1949 оны үйл явдлыг нэлэнхүйд нь тусган харуулжээ. Он жил улиран өнгөрөх тутам Хятадын хувьсгалын энэхүү ялалтын өмнөх төгсгөлийн хуудасны ач холбогдол, туршлага сургамж улам бүр товойн харагдаж байна. Тиймээс ч Хятадын чөлөөлөх хөдөлгөөний нарийн төвөгтэй үе шатууд Манжуурын хувьсгалт баазын гүйцэтгэсэн шийдвэрлэх үүрэг роль, тэрхүү хувьсгалт баазыг бататган бэхжүүлэхэд ЗХУ-ын үзүүлсэн тал бүрийн интернациональч тусламжийг арвин их баримт материалын үндсэн дээр үнэн зөвөөр тусган харуулсан зөвлөлтийн нэрт хятад судлаач эрдэмтэн О. Борисовын ном нь цаг үеэ олсон жинтэй бүтээл болжээ. Энэхүү номын үнэ цэнэ нь зөвхөн түүхэн үнэнийг сэргээн тодруулснаар хязгаарлагдахгүй, Хятадад хувьсгал ялахад олон улсын хүчин зүйл, ялангуяа Зөвлөлт улсын гүйцэтгэсэн үүрэг ролийг нуун дарах, бууруулж багасгах гэсэн элдэв завхруулах оролдлогыг няцаахад оршиж байна.

Түүнээс гадна Манжуурын хувьсгалт баазын түүхэн туршлага нь «Хятадын үндэсний өвөрмөц онцлог» болон социализм байгуулах нийтлэг зүй тогтлын харьцааны тухай асуудалд бодитой хариулт өгч байгаа юм. Тэрхүү туршлага нь Хятадад социализмыг гаднаас «экспортлон» оруулсан тухай зохиомол зүйлийг няцаагаад зогсохгүй шинжлэх ухааны социализмын нийтлэг зүй тогтлууд Хятадын нөхцөлд «үл тохирохыг» батлах гэсэн оролдлогын явцгүй болохыг илчлэн харуулж байна.

1945 оны наймдугаар сард ЗХУ-ын зэвсэгт хүчин Монголын ардын армийн хамтарсан хүчээр Квантуны армийг бутцохиж Зүүн Хойд Хятадыг чөлөөлсөн нь Хятадын хувьсгалын хувь заяанд түүхэн эргэлт гарсан юм. Үүнийг ч тухайн үед Мао Зэдун болон хятадын хувьсгалын бусад удирдагчид ямар ч эргэлзээгүй хүлээн зөвшөөрч байлаа. (66-67-р тал)

Японыг бууж өгсөний дараа Хятадын бүх нутаг дэвсгэр харилцан дайсагнасан хоёр талынханд хуваагдсаны нэгэн адил Манжуур ч хоёр хуваагдаад байв, АНУ-ын идэвхтэй дэмжлэг доор Чан Кайшигийн дэглэм Хятадын хувьсгалын хувь заяанд халдахаар илэрхий заналхийлэн байсан 1945—1946 оны энэ үед ЗХУ-ын авч хэрэгжүүлсэн улс төрийн болон дипломат тэмцлийн арга хэмжээнүүд тухайн үед туйлын зөв байсныг дараагийн үйл явдлууд батлан харуулсан билээ. 1945 оны эцсээр Хятадын нутаг дэвсгэрт АНУ-ын үйлдсэн зэвсэгт түрэмгийллийн үед ч ЗХУ-ын баримталсан интернационалч байр суурь нь Хятадын ард түмний үнэнч нөхөр нь хэн болох, заналт дайсан нь хэн болохыг бүр тэр үед хэлж өгсөн юм.

\*О. Борисов. Советский союз и маньчжурская революционная база (1945—1949) издание третье, дополненное и доработанное Москва «Мысль—1985»

1946-1947 онууд нь ХКН болон түүний зэвсэгт хүчний хувьд цэргийн талаар хүнд хэцүү жилүүд байв. Энэ үед ХКН-ын Төв Хороо ны штаб болж байсан Яньанийг гоминданы тал эзэлж авсан юм. Ийм нөхцөлд Хятадын хувьсгалын түшиг тулгуурын үүрэг гүйцэтгэх болсон Манжуурын хувьсгалт баазын зэвсэгт хүчний зохион байгуулалт, зэвсэглэл, бие хүчний өсөлт нь ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламжтай салшгүй холбоотой юм. Энэ нь ч хятадын хувьсгалын төгсгөлийн шатанд ХКН-ын зэвсэгт хүчний манжуурын бүлэглэл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн тухай дүгнэлтэд зохиогчийг хүргэжээ.

ХКН-ын удирдлагаар Манжуурын чөлөөлөгдсөн районд авч хэрэгжүүлсэн нийгэм-эдийн засгийн өөрчлөлтүүд улс төрийн чухал ач холбогдолтой байв. Тэдгээр нь хувьсгалт замыг, ХКН-ын нэр төрийг бэхжүүлж, түүний нийгмийн баазыг өргөтгөснөөс гадна ажилчин анги, тариачдын холбоог бэхжүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болжээ.

Манжуурын хувьсгалт баазыг бэхжүүлэхэд ЗХУ-ын үзүүлсэн тал бүрийн сэтгэл харамгүй тусламжийн тухай хэсэг уг номонд багагүй байр эзэлсэн нь зүй ёсны хэрэг билээ. Манжуурын хувьсгалт баазыг бэхжүүлэх үйл хэрэгт зөвлөлтийн нам, аж ахуйн олон тооны ажилтан, мэргэжилтнүүд гар биечлэн оролцох эрсдийн баялаг туршлагаа сэтгэл харамгүй танилжүүлэн өгч байв. Манжуурын хувьсгалт баазын эдийн засгийн амин чухал салбарууд болох аж үйлдвэр, зам харилцааг сэргээн босгож хэвийн ажилтай болгоход зөвлөлтийн инженер, техникчид голлох үүрэг гүйцэтгэжээ. Зөвлөлтийн төмөр замчдын асар их зүтгэл чармайлтын үр дүнд зөвхөн 1948 оны 12-р сарын 15 гэхэд нийт 15 мян км төмөр замын шугам, 9 мянган м-ийн урттай том, дунд хэмжээний 120 гүүрийг сэргээн босгож ашиглалтанд оруулжээ. (165-р тал) Энэ бүгд нь Хятадын хувьсгалт тэмцэлд Зөвлөлтийн ард түмний үзүүлсэн интернационалч тусламжийн нэгхэн хэсэг юм.

Хятадын хувьсгалын төгсгөлийн шатны нарийн төвөгтэй үйл явдлууд, тухайлбал Хятадын ард түмний тэмцэлд ЗХУ-ын үзүүлсэн интернационалч тусламжийн ач холбогдлыг бууруулах гэсэн оролдлого одоо хүртэл тасрахгүй байна. Иймээс ч энэ талаарх өрнөдийн хөрөнгөтний түүх зүй болон БНХАУ-ын түүх зүйн байдлыг задлан шинжилсэн О. Борисовын номын сүүлчийн бүлэг ихээхэн сонирхол татаж байна. Сүүлийн үед Бээжинд хэвлэгдсэн янз бүрийн ном хэвлэлд Зүүн хойд Хятадыг чөлөөлөх, Манжуурын хувьсгалт баазыг байгуулахад ЗХУ-ын гүйцэтгэсэн үүрэг ролийг хэрхэн тусгаж байгааг зохиогч буурьтай задлан шинжилж Хятадын хувьсгалын ялалтанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн энэхүү хүчин зүйлийг аль болохоор бууруулах, эсвэл шууд үгүйсгэх гэсэн аливаа оролдлогод нухацтай няцаалт өгчээ.

1945— 1949 оны Хятадын хувьсгалт тэмцлийн үйл явцыг гуйвуулах гэж түүх завхруулагчид хичнээн оролдовч энэхүү шийдвэрлэх үед ЗХУ тууштай интернационалч байр суурь баримталж байсныг өгүүлэн бүхий зохиолд орсон түүхэн баримт гэрчлэн харуулж байна.

Ийнхүү Хятадын хувьсгалын хувь заяанд олон улсын хүчин зүйл, ялангуяа ЗХУ-ын гүйцэтгэсэн үүрэг ролийг үнэн зөвөөр шинжлэх ухааны үндэстэй нэгтгэн дүгнэхэд 1975 онд анх хэвлэгдсэнээс хойш нийт гурав дахь удаагаа хэвлэгдэж байгаа уг зохиолын ач холбогдол оршиж байна.